



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 22

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Сүхбаатар сумын иргэн У.Энхбатын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Болорзул

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

Б.Энхбат

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

М.Нямсүрэн

-Шүүхийн Тамгын газрын дарга Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж, дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 06 дугаар сарын 08-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Болорзул/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.СУВДАА